



ШССМХ-ийн захирлын ... сарын
ны өдрийн тоот тушаалын 1 дүгээр хавсралт

"МОНГОЛЫН ТӨР, ЭРХ ЗҮЙ" СЭТГҮҮЛ ЭРХЛЭН ГАРГАХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Улсын дээд шүүхийн дэргэдэх Шүүхийн сургалт, судалгаа, мэдээллийн хүрээлэнгийн /цаашид "Хүрээлэн" гэх/ "Монголын төр, эрх зүй" сэтгүүл /цаашид "сэтгүүл" гэх/-ийн нийтлэлийн бодлого, удирдлага, зохион байгуулалт, эрхлэн гаргалт, түгээлттэй холбогдсон харилцааг энэхүү журмаар зохицуулна.

1.2. Сэтгүүлийг эрхлэн гаргагч нь Шүүхийн сургалт, судалгаа, мэдээллийн хүрээлэн байна. Хүрээлэнгийн захирал сэтгүүлийн журмыг батлах, нэмэлт, өөрчлөлт оруулах, сэтгүүлийн эрхлэгч, нарийн бичгийн дарга, зөвлөлийн бүрэлдэхүүнийг томилж, чөлөөлнө.

1.3. Сэтгүүл нь Хүрээлэнгийн өмч бөгөөд хууль зүйн шинжлэх ухааны болон Улсын дээд шүүхийн шийдвэр, шүүхийн практик судлалын ололт, амжилтыг хөхижүүлэн дэмжих, шүүхийн эрх зүйг хөгжүүлэхэд судлаач, хуульчдын онол, практикийн мэдлэг, үзэл бодлоо солилцох, өөрсдийн судалгаа, дүн шинжилгээ, ажлын тайланг олны хүртээл болгох мэдээллийн талбар байна. Мөн сэтгүүлийн эрхлэгч нь Хүрээлэнгийн үйл ажиллагааг сэтгүүлээр дамжуулан олон нийтэд хүргэж болно.

1.4. Сэтгүүл нь дараах хаягтай байна.

Хаяг: Улаанбаатар 15160, Бага тойруу, Чингэлтэй дүүрэг, Хангарьд ордон

Утас: 51-261811

И-мэйл: info@jtrii.gov.mn

Хоёр. Сэтгүүлийн нийтлэлийн бодлого

2.1. Сэтгүүл нь төр, эрх зүйн онол, арга зүй, эрх зүйн салбар, шүүхийн практик судлал, харьцуулсан шүүхийн эрх зүйн эрдэм шинжилгээ, судалгааны ажил /цаашид "бүтээл" гэх/ болон холбогдох мэдээ, мэдээллийг түгээх, эрх зүйн шинжлэх ухааныг хөгжүүлэхэд чиглэнэ.

2.2. Сэтгүүлд нийтлэгдсэн бүтээл нь зохиогчийн оюуны өмч байх бөгөөд уг бүтээлийн ашиглалт, эрх зүйн хамгаалалт нь хууль тогтоомжид заасны дагуу зохицуулагдана.

Гурав. Сэтгүүлийн удирдлага, зохион байгуулалт

3.1. Сэтгүүлийн удирдлагыг Сэтгүүлийн зөвлөл хэрэгжүүлнэ. Сэтгүүлийн зөвлөл нь эрхлэгч, нарийн бичгийн дарга, гишүүд /шүүгч, эрдэмтэн, судлаач/-ээс бүрдэнэ.

3.2. Сэтгүүлийн эрхлэгч нь тухайн сэтгүүлийн нийтлэлийн бодлогыг хэрэгжүүлж, зөвлөлийн хуралдааныг удирдаж, сэтгүүлийг эрхлэн гаргах үйл ажиллагааг зохион байгуулж, сэтгүүлийг төлөөлөх бөгөөд сэтгүүлд нийтлүүлэх бүтээлийн хянан магадалгааны загварыг батална.

3.3. Сэтгүүлийн зөвлөлийн гишүүний чиг үүрэг:

3.3.1.сэтгүүлийн бодлого, чиглэлийг тодорхойлох, түүний хэрэгжилтэд хяналт тавих;

3.3.2.сэтгүүлийн үйл ажиллагаанд үнэлэлт, дүгнэлт өгөх, сэтгүүлийн захиалгын үнийг тогтоох;

3.3.3.мэргэшсэн чиглэлийнхээ хүрээнд сэтгүүлд нийтлүүлэх бүтээлийн хянан магадалгаа хийж уг бүтээлийг нийтлэх, дахин сайжруулах, эсхүл нийтлэхээс татгалзах талаар “Эрдэм шинжилгээний өгүүллийг үнэлэх, дүгнэлт гаргах хуудас” (Хавсралт 2) -д заасан үзүүлэлтийн дагуу ажлын 10 өдрийн дотор дүгнэлт гаргах.

3.4.Сэтгүүлийн зөвлөлийн үйл ажиллагааны хэлбэр нь хуралдаан байх бөгөөд хуралдааныг сэтгүүлийн эрхлэгч зарлан хуралдуулна. Хуралдаан нь гишүүдийн олонх хүрэлцэн ирснээр хүчинтэй болох бөгөөд асуудлыг хуралдаанд оролцсон гишүүдийн олонхын саналаар шийдвэрлэнэ.

Дөрөв.Сэтгүүлд нийтлэгдэх бүтээлийг хянан магадлах, түгээх

4.1.Сэтгүүлийн редакцын зөвлөлийн гишүүнд урьдчилсан хяналт хийлгэхээр ирүүлсэн бүтээлийг хүргүүлэх тохиолдолд түүний хугацаа, унших хөлсийг баталгаажуулна.

4.2.Сэтгүүлийн нарийн бичгийн дарга сэтгүүлийн сурталчилгаа, хэвлэлийн эхийг хүлээн авах, сэтгүүлийг хэвлэлтэд өгөх, хуваарилах ажлыг хариуцаж дараах ажил үүргийг гүйцэтгэнэ:

4.2.1.сэтгүүлд ирүүлсэн бүтээлийг хүлээн авч, хэлбэрийн шаардлага хангасан бүтээлийг сэтгүүлийн зөвлөлийн гишүүдэд (мэргэшсэн чиглэлийг харгалzan) хуваарилан хянуулах;

4.2.2.мэргэжлийн түвшинд, хөндлөнгийн хяналтыг хэрэгжүүлэх редакцын зөвлөлийн гишүүний үйл ажиллагаа нь сэтгүүл хэвлэгдэн гарахаас 1 сарын өмнө хийгдсэн байвал зохино. Хэрэв дурдсан хугацаанд редакцын зөвлөлийн гишүүн бүтээлд урьдчилсан хяналт хэрэгжүүлж чадаагүй, эсхүл зохиогчоос шаардлагатай засварыг хийж хүргүүлээгүй бол дараагийн дугаарт нийтэлж болно.

4.2.3.редакцын зөвлөлийн гишүүний агуулгын хувьд хянасан бүтээлийг цаашид сэтгүүлд нийтлэх эсэх талаарх дүгнэлт, эсхүл цаашид бүтээлийг сайжруулах талаарх саналыг “Эрдэм шинжилгээний өгүүллийг үнэлэх, дүгнэлт гаргах хуудсаар” дамжуулан зохиогчид хүргүүлж мэдэгдэнэ;

4.2.4.редакцын зөвлөлийн гишүүний дүгнэлт, саналын дагуу зохиогчоос шаардлагатай засвар, нэмэлтийг оруулан ирүүлсэн бүтээлийг шаардлагатай тохиолдолд хянан магадалгаа хийсэн редакцын гишүүнд дахин шалгуулна;

4.2.5.сэтгүүлд нийтлэгдэх бүтээлийг нэгтгэн эрхлэгчид танилцуулж, зөвшөөрлийг гарын үсэг зуруулан авч, хэвлэлтэд өгөх;

4.2.6.шуудангаар дамжуулан захиалагчид үнэ төлбөргүй тараах, сэтгүүлд бүтээлээ хэвлүүлсэн зохиогчид болон шүүгчийн жагсаалтыг шүүх, бусад байгууллага тус

бүрээр гаргаж, нийт хэвлэгдэх сэтгүүлийн тоог няглан бодогчид өгөх, хэвлэх зардлыг хэвлэлийн компанийд шилжүүлэх ажлыг зохион байгуулах;

4.2.7.хэвлэлтээс гарсан сэтгүүлийг хуваарилж, их дээд сургууль, холбогдох байгууллагуудын номын сан болон захиалагчид түгээх шуудангийн байгууллага, нийслэлийн шүүхийн шүүгчдэд түгээх бичиг хүргэгч, бүтээлээ хэвлүүлсэн зохиогч тус бүрт тухайн дугаарын сэтгүүлийн хоёр хувийг ажлын 10 хоногт багтаан хүргэх ажлыг зохион байгуулах;

4.2.8.Шүүхийн ерөнхий зөвлөл, Хууль зүйн үндэсний хүрээлэн, Дотоод хэргийн их сургууль, МУИС-ийн Хууль зүйн сургуулиас эрхлэн гаргадаг "Шүүх эрх мэдэл", "Хууль дээдлэх ёс", "Хууль сахиулахуй", "Эрх зүй" зэрэг сэтгүүлийн дугаарыг харилцан солилцох ажлыг зохион байгуулах.

4.3.Сэтгүүлийг хэвлэх, түгээхтэй холбогдсон зардлыг Хүрээлэнгээс гаргана. Няглан бодогч сэтгүүлийн захиалга, санхүүгийн тооцоо, тайлан, гүйлгээ, гүйцэтгэлийг хариуцах ба сэтгүүлийн Улаанбаатар хот доторх түгээлтийг бичиг хүргэгч хүргэнэ.

4.4.Сэтгүүлийн эрхлэгч, нарийн бичгийн дарга, сэтгүүлийн санхүү болон түгээлт хариуцсан ажилтны энэхүү журмаар хүлээсэн үүргийг тухайн ажлыг хавсран гүйцэтгэж байгаа ажилтны ажлын байрны тодорхойлолтод тусгана.

4.5.Сэтгүүлд нийтлүүлэх бүтээлд хянан магадалгаа хийхэд нарийн мэргэшсэн мэргэжилтэн шаардлагатай тохиолдолд Сэтгүүлийн зөвлөл хэлэлцэн холбогдох мэргэжилтнээр хянан магадалгаа хийлгүүлж болно.

Тав.Сэтгүүлд нийтлэх бүтээлд тавих нийтлэг шаардлага

5.1.Сэтгүүл нь нийтлэлийн бодлогод нийцсэн сэдэмж /эссэ/, эрдэм шинжилгээний өгүүлэл, олон улсын ба гадаад улсын шүүхийн байгууллагын туршлага, мэдээ, судалгааны тойм, шүүхийн шийдвэрийн шинжилгээ, эрдэм шинжилгээний бүтээлийн шүүмж, эх сурвалжийн танилцуулга, орчуулга, ярилцлага зэргийг нийтлэх бөгөөд дараах булантай байна:

5.1.1.Эрдэм шинжилгээний өгүүлэл, судалгааны тойм;

5.1.2.Шүүхийн шийдвэрийн шинжилгээ;

5.1.3.Үзэл бодол /сэдэмж, ярилцлага, шүүмж/;

5.1.4.Мэдээ, мэдээлэл /эх сурвалж, орчуулга/.

5.2.Сэтгүүлд эрх зүй ба эдийн засаг, эрх зүй ба бизнес, эрх зүй ба байгаль орчин гэх мэт салбар дундын асуудал хөндсөн бүтээлийг хэвлэж болно.

5.3.Сэтгүүлийн зөвлөл тодорхой сэдвээр энэ журмын 5.1-д заасан бүтээлийг судлаачдад захиалж бичүүлэн сэтгүүлд нийтэлж болно.

5.4.Сэтгүүлд нийтлэгдэх бүтээл нь дараах шаардлагыг хангасан байна.

5.4.1.сэтгүүлд нийтлүүлэхээр ирүүлж байгаа бүтээл нь өмнө ямар нэгэн байдлаар бусад сэтгүүлд нийтлэгдээгүй байна;

5.4.2.сэтгүүлд нийтлүүлэхээр ирүүлэх бүтээл нь хэл зүйн хувьд эрдэм шинжилгээ, судалгааны ажилд тавигдах шаардлага хангасан байх бөгөөд бүтээлийн төрлөөс үл хамааран зохиогчийн эрхийг нэн тэргүүнд хүндэтгэн үзэж, эшлэл, зүүлт авсан байна. Эшлэл, зүүлт авахдаа Хүрээлэнгээс баталсан “Эшлэл хийх, эх сурвалжийг заах, ном зүйн бичилт хийх стандарт”-ыг баримтална;

5.4.3.сэтгүүлд нийтлүүлэх бүтээлийг Microsoft Word программаар бичсэн 12pt хэмжээтэй Times New Roman фонтоор, мөр хоорондын зاي 1.0-ээр бэлтгэсэн, 1500-аас доошгүй үгтэй хэлбэрийн шаардлагыг хангасан байна;

5.4.4.оршил болон үндсэн хэсэг, дүгнэлт, зөвлөмжийг дугаарлахдаа ромбо (I, II гэх мэт) тоогоор дугаарлана. Бүтээлийн ерөнхий гарчиг нь 12pt хэмжээтэй Bold, ТОМ ҮСГЭЭР, Дэд гарчгууд нь 11pt үсгийн хэмжээтэй Bold форматтай, Бичвэрийн үсгийн фонт – [Times New Roman, 11pt, мөр хоорондын зай 1, баруун зүүн талаасаа зэрэгцсэн байна].

5.4.5.өгүүллийн дэд хэсгийг дугаарлахдаа ромбо (I, II, III гэх мэт) тоогоор дугаарлана. Дэд хэсгийг дотор нь дугаарлахдаа тоогоор дугаарлана (1, 2, гэх мэт). Цаашид нарийвчлан дугаарлах тохиолдолд жижиг үсгээр цагаан толгойн дарааллаар (а, б, с гэх мэт) дугаарлана.

5.4.6.бүтээлийг А-4 хэмжээний хэвлэсэн болон цахим хэлбэрээр ирүүлнэ;

5.4.7.бүтээлийг зохиогчийн нэр, хаана ямар ажил эрхэлдэг, эрдмийн зэрэг, цол, цахим шуудангийн хаяг, утасны дугаар, зохиогчийн гэрэл зургийн /4x6 хэмжээтэй цээж зураг/ хамт ирүүлнэ.

5.5. Дээрх 5.4-д дурдсан хэлбэрийн шаардлагыг хангаагүй бүтээлийг хүлээн авахаас татгалзах бөгөөд энэ тухай мэдэгдэнэ.

Зургаа.Сэтгүүлд нийтлэх бүтээлд тавигдах тусгай шаардлага

6.1.Эрдэм шинжилгээний өгүүлэл

6.1.1.Эрдэм шинжилгээний өгүүлэл нь үндэсний эрх зүйн онол, практикт тулгамдсан асуудлыг хөндсөн, түүнийг шийдвэрлэх талаар санал, дүгнэлтийг шинжлэх ухааны үндэслэлтэй гаргасан байна.

6.1.2.Эрдэм шинжилгээний өгүүлэл нь дараах ерөнхий бүтэцтэй байна:

- 1) Эрдэм шинжилгээний өгүүллийн нэр;
- 2) Түлхүүр үг;
- 3) Хураангуй;
- 4) Оршил, танилцуулга;
- 5) Сэдвийн судлагдсан байдлын талаар бүтээл, эх сурвалжийн тойм;
- 6) Үндсэн хэсэг,
- 7) Дэд хэсэг;
- 8) Дүгнэлт, санал зөвлөмж;
- 9) Ном зүй.

6.1.3.Өгүүлэл нь эшлэл, зураг, хүснэгт, график, тайлбарыг оролцуулан 4000-аас багагүй үтэй байна.

6.1.4.Эрдэм шинжилгээний өгүүллийн нэр, түлхүүр үг, өгүүллийн хураангуйг монгол ба англи хэлээр бичсэн байна.

6.1.5.Эрдэм шинжилгээний өгүүллийг англи болон бусад хэлээр хэвлэж болно.

6.1.6.Эрдэм шинжилгээний өгүүлэлд 5-10 хүртэл түлхүүр үгийг бичсэн байна.

6.2.Судалгааны тойм

6.2.1.Судалгааны тойм гэдэгт хууль зүйн шинжлэх ухааны хүрээн дэх аливаа төсөл, эрдэм шинжилгээ, судалгааны ажлын тайлан, үр дүнгийн танилцуулга, тойм, хураангуй зэргийг ойлгоно.

6.2.2.Судалгааны тойм нь А-4-ийн хэмжээтэй 3-5 нүүр байна.

6.2.3.Тухайн сэдвээр судлаачдын бүтээлээс эшлэл авсан байна.

6.3.Шүүхийн шийдвэрийн шинжилгээ

6.3.1.Шүүхийн шийдвэрийн шинжилгээ нь хууль хэрэглээний нэг мөр байдлыг болон шүүхийн шийдвэрийн бичвэрийн хууль зүйн техникийг дээшлүүлэхэд чиглэх ба шинжилгээ хийж байгаа шийдвэр нь давж заалдах, эсхүл хяналтын шатны шүүхээр эцэслэн хянагдсан байна.

6.3.2.Шүүхийн шийдвэрийн шинжилгээ нь сэтгүүлийн нэг дугаарт эрүү, иргэн, захиргааны чиглэлээр нийт таваас илүүгүй байна.

6.3.3.Судлаачдын бүтээл, ном, гарын авлага ашигласан тохиолдолд түүнийг эшилбэл зохино.

6.4.Эрдэм шинжилгээний бүтээлийн шүүмж

6.4.1.Эрдэм шинжилгээний бүтээлийн шүүмжийг тухайн бүтээлийн зохиогчоос өөр судлаач бичсэн байна.

6.4.2.Эрдэм шинжилгээний бүтээлийн шүүмж нь тухайн бүтээлийн шинжлэх ухааны үнэ цэн, шинжлэх ухаанд оруулах хувь нэмэр, онолын болон практик ач холбогдолд үнэлэлт өгсөн байх бөгөөд зохиогчийн академик эрх чөлөөг хүндэтгэсэн байна.

6.5.Эх сурвалж, орчуулга

6.5.1.Сэтгүүлд ховор, шаардлагатай эх сурвалж, орчуулгыг хэвлүүлж болно. Ингэхдээ тэдгээрийн судалгааны ач холбогдлыг нэн тэргүүнд харгалзан үзнэ.

6.5.2.Эх сурвалж, орчуулгын үнэн зөв эсэхийг нягтлах, татгалзах эрх сэтгүүлийн зөвлөлд хадгалагдана.

6.5.3. Эх сурвалж, орчуулгыг ирүүлэхдээ эх сурвалж хаана, хэзээ хэвлэгдсэн буюу бий болсныг таньж болохуйц байдлаар хавсарган сэтгүүлийн зөвлөлд хүргүүлнэ.

6.6. Ярилцлага

6.6.1. Сэтгүүлийн зөвлөлөөс зөвшөөрсөн буюу захиалсан асуудлаар ярилцлага хийж болно.

6.6.2. Ярилцлага нь сэтгүүлийн нэг дугаарт нэгээс илүүгүй байх бөгөөд хуудасны хэмжээ А4-ийн 5 нүүрнээс ихгүй байна.

6.7. Сэдэмж

6.7.1. Эрдэм шинжилгээний сэдэмж нь хууль зүйн шинжлэх ухааны хүрээн дэх аливаа асуудлаар өөрийн үзэл бодол, санааг илэрхийлэн эхлэл, өрнөл, төгсгөл буюу дүгнэлт хэсэгтэй байна.

6.7.2. Сэдэмж нь 1000-аас дээшгүй үтгэй байна.

Долоо. Сэтгүүлийн санхүүжилт, түүний зарцуулалт

7.1. Сэтгүүлийг хэвлүүлэх, түгээхтэй холбогдсон зардлыг Хүрээлэнгээс санхүүжүүлнэ.

7.2. Сэтгүүлийн эрхлэгч, нарийн бичгийн дарга, гишүүд, нийтлүүлэгчид "Оны шагналтан"-ны урамшууллыг Хүрээлэнгийн захирамжаар олгоно.

Найм. Сэтгүүлийг хэвлэх хугацаа

8.1. Сэтгүүлийн зөвлөлөөс тухайн бүтээлийг хянан үзэж, хэвлэх эсэхийг шийдвэрлэнэ.

8.2. "Монголын төр, эрх зүй" сэтгүүлийг улиралд 1 удаа, жилд 4 удаа эрхлэн гаргах бөгөөд улирал тутмын дугаарыг 2, 6, 9, 12 дүгээр сарын 15-ны дотор тус тус хэвлүүлнэ.

8.3. Тэмдэглэлт үйл явдал, түүхэн ойн баярт зориулж тусгай дугаарыг монгол, эсхүл гадаад хэлээр гаргаж болно.

8.4. Сэтгүүлийн талаарх мэдээлэл, шинэ дугаарыг гарсан даруй Хүрээлэнгийн цахим хуудаст нээлттэй байршуулах бөгөөд Монгол улс дахь нийт шүүх, шүүгчид руу цахим хэлбэрээр хүргүүлнэ.

Ес. Журамд нэмэлт, өөрчлөлт оруулах

9.1. Энэхүү журмыг "Монголын төр, эрх зүй" сэтгүүлийн редакцын зөвлөлөөр хэлэлцэн Хүрээлэнгийн захирлын тушаалаар батална. Уг журамд оруулах нэмэлт, өөрчлөлтийн саналыг сэтгүүлийн зөвлөлийн гишүүн, сэтгүүлийн ажлын алба гаргаж болно.

9.2. Журамд оруулах нэмэлт, өөрчлөлтийг сэтгүүлийн редакцын зөвлөлийн гишүүдийн олонхын саналаар шийдвэрлэнэ.

9.3. Журамд оруулах нэмэлт, өөрчлөлт нь энэхүү журмын салшгүй хэсэг болно.

---оо---

